



## БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 7/08

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн  
2022 оны хагас жилийн тооллогын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.2, 72.4, 72.5 дах заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бэлчээрийн менежмент төслийн нэгж орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгө, эд материалын тооллого явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Пүрэвсүрэн

Төслийн менежер

Гишүүдэд:

Б.Отгонжаргал

Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн

Б.Зинамядраа

Механик

Нарийн бичиг:

Б.Баярцэцэг

Агрономч

2. Тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, эд хөрөнгийг нүдээр үзэн тоолж, цаашид ашиглах боломжгүй эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж, тооллогын үр дүнг удирдлагад танилцуулж ажиллахыг комиссын ахлагч (Г.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Тооллогын явцад өртгөө элэгдлээрээ нөхсөн буюу эвдэрч хуучран шаардлага хангахгүй болсон хөрөнгийг тоолж, худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах талаар санал гарган зурагжуулж, Нийслэлийн Өмчийн харилцааны газраар дүгнэлт гаргуулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэн данс бүртгэлээс хасаж, тайлан тооцоонд тусгахыг Нягтлан бодогч (Ц.Мөнхдөл)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.УУГАНБАЯР

